

СОЦИАЛИЗМЫН ҮЕД ШАШНЫ ЭСРЭГ ҮЗЭЛ САНААГ МОНГОЛЫН  
ТОГТМОЛ ХЭВЛЭЛД ТУСГАЖ БАЙСАН НЬ

Б.Болд-Эрдэнэ\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** олон нийтийн санаа бодол, хэлмэгдүүлэлт, шашны эсрэг ухуулга сурталчилгаа, шарын шашин.

Өдгөөгөөс 100 жилийн өмнө 1921 онд Монгол орноо дүрвэсэн Барон Унгерн тэргүүтэй оросын цагаан хааны цэргийг үлдэн хөөх шалтгаанаар Зөвлөлтийн большевик засгийн улаан армитай Ардын намын партизанууд нэгдэн Их Хүрээг чөлөөлснөөр коммунист дэглэм тогтох боломж нөхцөл бүрэлдсэн билээ. Тухайн үед Богд хаан Монголын шашин, төрийн тэргүүн, буддын шарын шашин ард малчдын оюун санаа, ертөнцийг үзэх үзэлд гүн бат эрхшээсэн, сүм хийд нийгмийн амьдрал харилцаанд бодит нөлөөтэй, хутагт хувилгаад өөрийн шавь нарыг захиран суудаг, мал хөрөнгө үлэмж их жасын сан хөмрөгтэй байсан. Түүнчлэн Монгол орон 100 гаруй мянган лам хуврагтай, 600 орчим том хүрээ хийд, 1000 гаруй шашны хурлын жижиг дуган (БНМАУ-ын түүх. II дэвтэр, 1966), 100 гаруй хутагт хувилгаадтай, тэднээс тамгатай 13 хутагт нь эзэмшилдээ 70 мянган толгой мал, 30 гаруй мянган ам бүл бүхий 7000 орчим өрхийг шавь болгон эрхшээж байжээ.

Тиймээс Монгол ардын намын удирдлага шашин төрийг тусгаарлаж, Богд хаанд сүм хийд, лам, сүсэгтнүүдийн харилцаа, амьдралыг мэдэх, захирах эрхийг үлдээснээр шашны эсрэг бодлого, үйл хэргийг түүчээлж коммунист суртал ухуулгын кампанит ажлыг эхлүүлжээ. Ийнхүү 1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Ардын засгийн газрын тогтоолоор Богд хааны төр шашны эрхийг зааглан тогтоосон Тангаргийн гэрээ хэмээх эрхзүйн баримтыг баталсан. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд “Монгол Улсын Богд хаан Жавзандамба хутагт шарын шашны богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино” (Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, 1956) хэмээн зааж, төр шашны эрхийг тусгаарлажээ.

Шашны эсрэг ухуулга сурталчилгаа нь юуны өмнө шашингүй үзлийг олон нийтийн санаа бодол, хувь хүний ертөнцийг үзэх үзэлд төлөвшүүлэх зорилго дор зохион байгуулагддаг мэдээлэл, харилцааны хэлбэр билээ. Нөгөө талаар шашингүй үзэл нь коммунист хүмүүжлийн салшгүй хэсэг, шашныг боловсрол, төрөөс тусгаарлах үзэл ба-

римтлалын тулгуур үндэслэл шүтэх, эс шүтэх хүний эрхийн гол зарчим болой.

Гэтэл Монголын хувьсгалчид засгийн эрхийг авсны дараах жилүүдэд буюу 1924 он хүртэл шашныг үгүйсгэх, шууд дайсагнан довтолох бодит нөхцөл үгүй, тэдний дотор ч шашны өндөр мэдлэгтэй (Бодоо) сүм хийдэд шавилан сууж байсан (Х.Чойбалсан) нөлөө бүхий удирдагчид байсан. Монголын ард малчид коммунист үзэл онолын ямар ч мэдлэг төсөөлөл үгүй, нийгмийн үнэлэмж, эрүүл мэнд, амьдралын хэв маягтаа шашны дэг, хэм хэмжээ, эмчилгээг эрхэмлэдэг зэрэг бодит хүчин зүйл оршин байв.

**И**йнхүү 1924 оноос Монгол Ардын намын төв хороо, Засгийн газрын хэвлэл “Ардын эрх” сонинд (1924 оны 2 сараас 1925 оны 4 сар хүртэл 50 дугаар гарсан 40\*56см, 4-8 нүүр) шашны эсрэг үзэл санааг сурталчлахад багагүй тооны нийтлэл, мэдээг зориулжээ. Сонины нийтлэлийн агуулга нь их төлөв лам хуврагийн шашны номын ёс, дэг жаягаа алдан, ховдог шунахай, садар самуун, зүй бус явдалтай болсныг жишээ баримт түшиглэн шүүмжилж, ялзран доройтсон тухай сурталчилж байв. Тухайлбал сонины (№2, 1924.02.23) 2 дахь дугаарт “Өөрийн толгой дээрх тэмээг анхаарсангүй өгүүлэлд” Монголын олон лам нарыг гурван хувь хуваахад хоёр хувь нь хороо харчуудын газар эмийг авч гэрийг эзлэн өчнөөн төчнөөн шарын хүүхдийн эцэг болон эмс охидоо элдвээр гоёж чимээд толгой дээрээ гаргаж эрхлүүлсээр бүхий атал эрдэмтэн хайрхан гавж, аграмба нар энэ мэт шашны ёс, сайн ламаас авсан санваар сахилаа алдуулан самуун садар явдал үүсгэн шашнаа доромжилсон, савсаг лам нараа сайн удирдан шашин бурхнаа сааргүй хүндэтгэхийг хичээхгүй

хэмээн Ардын засгийн газрын суртал ухуулгыг буруушаасан том лам нарын үг яриаг эсэргүүцэн бичжээ.

Энэхүү өгүүллийн үргэлжлэл 5 дахь дугаарт “Өмнөх үргэлжлэл” гарчигтай нийтлэгдэж лам Хамсум хэмээгч сүсэгтэн олныг хуурч ихээхэн хэмжээний хандив өргөл барьц цуглуулан явахдаа “... аливаа хүнийг бага юм өгөв хэмээн барин хүлж, мөнгө янчаан, алтан бөгж, мөнгөн эдлэл, мал зэрэг үлэмжхэн юм олж ирээд тэрхүү юмыг бүр уг зүйлд зарцуулсангүй” гээд “... бурхны нэрийг зааж, өөрийн завшааныг хичээн, олныг мөлжин, өөрийн биеийг гоёж чимээд явах нь чухамхүү харин шунахай аргат этгээд даруй мөн” гэж дүгнэн төгсгөжээ. Ийм суртал ухуулгат агуулга бүхий нийтлэлийг дурдвал “Ардын мунхруулагч шар харгис мөн” (АЭ, №25, 1924.9.15), Зүрхний бишрэлээс үүджээ (АЭ, №36, 1924.11.18), “Ариун, бузрыг ялгая” (АЭ, №37, 1924.11.28), “Манайд хувраг ямар хэрэгтэй вэ” (мөн дугаар), Нутгийн сонин: “Энэ ямар хэрэг вэ” (АЭ, №39, 1924.12.16), Олны сүсгийг доромжилвой (АЭ, №40, 1924.12.24), “Эзэрхгүүд шашин хэмээгээд шашныг хорложээ” (АЭ, №43), “Сүсэгтэн сонсмуу” (АЭ, №45) зэрэг болно. Дээр тоочсон өгүүлэл, мэдээний гарчгийн утгыг л хөөхөд сүсэгтэн олны олон зуун жил шүтэн дээдэлсэн үнэлэмж итгэл дээдлэхүйг лам нар гутаан доромжилж, тэрсүүлэн гажуудуулж буй тухай ухуулан сэнхрүүлж байсан нь тодорхой бөгөөд тухайн цаг үеийн олон нийтийн санаа бодолд дуулиан шуугиан, ер бусын цочирдом үйл явдал, баримтыг түгээж байсан хэрэг билээ. Нэн ялангуяа Заяын гэгээний тухай онцлон түүний садар завхай, эд хөрөнгөд шунан донтогч болохыг баримтаар өгүүлээд “Нөхөд өө Бурханы нэрийг

барьж, будангуйран самуурагч ийм этгээдийг сонсоод бөөлжис нэн их хутгамой” (АЭ, №46) гэж уриалж байжээ.

Нөгөө талаар шашны эрхэм дээд төгс дүрээр Богд хааныг өргөмжилж, эсрэгцүүлэн тодотгосон “Бэлэвсрэлийг улс нийтээр үйлдмүү” (АЭ, №12, 1924.6.4) өгүүлэлд Богд хааныг олонтоо чилээрхэн, таалал төгссөнд Ардын засгийн газрынхан ихэд гашуудан, албан хаагчдад 3 өдрийн чөлөө олгон, бүх нийтээр 3 долоо хоног баяр цэнгэлийг хориглоод, улсын сангаас 3 мянган ланг буяны үйлд хандивлан, шарилыг залах өдөр цэрэг жагсаан их ёслол үйлдэхийг мэдээлэн, “... Богд хаантан болбоос анх дүрийн Богд Өндөр гэгээнээс эхлэн найман дүр хүртэл халхын газар залагдаж ард олны манлай багш болон шүтэгдэж, шарын шашныг дэлгэрүүлэх амьтны тусыг үйлдсээр ирсэн их лам бөгөөд ... Монголын ард түмнийг харь этгээдийн дарлалаас ангижруулахад санаа тавьсан ба ... тамгат бичгийг Зөвлөлийн засагт Орос улсаас тусламж гуйж явуулаад, тэр хэрэг зорилт гүйцэлдэж харгис дайсныг хядан арилгаж, хөөн зайлуулаад, ардын эрхт хэмжээт цаазат засгийг байгуулахад Богд хаан танаас их л сайшаан зөвшөөрч, Ардын засгийн хэргийг улмаар хүчин төгөлдөр болгон явуулахыг эрмэлзсэн зэргийн гавьяа тус мөн ч их. Одоо ийнхүү таалал төгссөн нь үнэхээр хайрлалтай, гомдолтой болой” хэмээн дүгнэжээ. Гэхдээ энэхүү өгүүлэлд Богд хааныг эрхэм гэгээнтэн төдийгүй ардын хувьсгалыг дэмжигч, шууд оролцогч цаашилбал түүний ивээл, хишгээр төр улс зөв үнэн, сайн замыг олсон гэсэн ухуулга сурталчилгааг дагуулан олон нийтийн гүн бишрэлийг Ардын засагт татахыг эрмэлзжээ.

1924 оны 11 дүгээр сарын 26-нд Улсын анхдугаар их хурлаас “Үндсэн хууль”-ийг баталж, Бүгд найрамдах засаглалыг тунхаглан, Коминтерны шууд тулгалт шахалтаар, гадаадын болон дотоодын хөрөнгө бүхий хэсгийг шахан зайлуулах, сүм хийд жасын мал, мөнгө, үнэт эдлэлийг хураах бодлогыг хэрэгжүүлэх болсноор МАХН болон Залуучуудын эвлэлийн Төв хорооны хэвлэл “Үнэн” сонины агуулга, ухуулга сурталчилгаанд “Сүм хийд, жасын хөрөнгийг хураах үед ард олны сүсэг бишрэлийг алдагдуулахгүй байхад чиглэсэн нийтлэл”-ийн бодлогыг хэрэгжүүлэхийг онцолжээ.

Ийнхүү лам нарыг нийгмийн давхраажилтын хувьд (коммунист үзлээр бол ангийн хувьд) үгүй болгох ингэхдээ нэгдүгээрт, өмч хөрөнгөгүй, хоёрдугаарт, удирдагч лидергүй (Богд Жавзандамба хутагтын дараа төрлийг тодруулахгүй байх), гуравдугаарт, доод ядуу лам нарыг дээд хутагт, хувилгаадтай тэрсэлдүүлэх, энгийн хар болгох зэрэг улс төрийн сөрөг ажлыг зохион байгуулж эхлэв.

**Т**иймээс ч PR-ын онолын үндсэн зарчим болох түлхүүр мэдээллийг (жасын хөрөнгийг хураан ядуу, доод ардад хуваан, хувь хүртээх) зорилтот бүлэгт (доод, ядуу лам нар, хамжлагат ард) хүргэх зорилго дор мэдээ нийтлэлийг түгээж байв. Энэ тухай Үнэн сонины “Нам ба энгийн олон ардын тухай” (Үнэн, №1, 1927) өгүүлэлд “...Сүм хийдийн малыг ардуудад гэрээгээр шилжүүлж, жасын хөрөнгөнд албан татвар ноогдуулан сул чөлөөтэй байсан хөрөнгийг хураах, хар болсон ядуу лам нарт хувь олгуулах арга хэмжээ авсныг том лам нар эсэргүүцэн, бурхан шашныг доройтуулах гэсэн санаа хэмээн эгдүүцэн зэвүүцэж байгааг илчлэн бичжээ” (Норовсүрэн.Л, 2011) хэмээн

профессор Л.Норовсүрэн дүгнэсэн нь тухайн цаг үеийн шашны эсрэг үзэл санааны тулгуур сурталчилгааны жишээ юм. Ийм нийтлэл, өгүүллийн жишээнд “Жасын кампанийн анхдугаар бүртгэл” (Үнэн, №56. 1930.10.13), “Феодал нарын хөрөнгийг хураах тухай” (Үнэн, №49. 1929.10.4), “Орон нутгийн газраас хар шар феодалын хөрөнгө хураахаар явсан гишүүдээс уг хэргийг хэрхэн гүйцэтгэсэн тухай” (Үнэн, №62. 1929.12.25), (Үнэн, №57. 1929.11.23) зэргийг тоочиж болно.

Энэ тухай доктор Г.Дэлэг “Нэгд хуучин ноёд хутагт хувилгааны хөрөнгө бол уулаас ард олны шүүсийг шимж элдвээр дарлан мөлжиж хураан хуримтлуулсан хөрөнгө болох тул тэдэнд зөвхөн амьжиргааг үлдээж, буцад үлдсэн зүйлийг цөм хураан авч ядуучууд бидний гарт олгуулахыг хүснэ” (Дэлэг.Г, 1972) гэсэн ухуулга бүхий өгүүлэл (Үнэн, №57. 1929.11.23) нийтлэгдсэнийг

онцолжээ. Ийнхүү 1929 онд л гэхэд 427 феодал хутагт хувилгаан, 302 түшмэдээс бүгд 4793392 төгрөгийн үнэ бүхий мал, 430 мянга орчим төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, нийт 5 сая 222 мянган төгрөгийн хөрөнгө хүртжээ. Эдгээр хөрөнгө-нөөс 1 сая 700 мянган төгрөгийн мал, эд зүйлийг ядуу ард

олонд хуваарилан шилжүүлэхийн хамт усад мал хөрөнгийг 130 хамтралд шилжүүлжээ. (Үнэн, 1932)

Мөн сонины өгүүлэлд 1929-1932 оны 4 сар хүртэл давхардсан тоогоороо 1100 илүү хар шар феодал, түшмэдээс 10 сая төгрөгийн хөрөнгө хурааж, ядуу 71 мянга гаруй ам бүлтэй 25235 өрхөд хөрөнгө шилжүүлж, хотын ядууст хүнс

тэжээлийн зүйл олгосныг тэмдэглэсэн нь бий. Түүнчлэн Үнэн сонинд (Үнэн, №60. 1932.3.12) “... намын VIII их хурлаас хойш 30 мянган лам хар болж, лам нарын тоо 101 мянгаас 75 мянга хүр-тэл буурсан” тухай мэдээлжээ.

Энэ үеийн ухуулга сурталчилгаа нь бодит үйл явдал, нийгэм цаг үеийн үзэгдэлд тулгуурлан (сүм хийдийн хөрөнгө хураах, ядуу лам нарыг хар болгох, хөрөнгийг үгээгүйчүүдэд хуваах зэрэг) нам, төрийн бодлого, шийдвэрийг сэнхрүүлэх зорилго дор зохион байгуулагдаж байснаараа онцлог бүхий болно. Түүнчлэн лам нарыг давхраажилтын хувьд устган үгүй хийх олон нийтийн санаа бодол, хандлагыг төлөвшүүлэх нөхцөл орчныг бүрдүүлэх суурь эхлэлийг тавьж, цаашдын хэлмэгдүүлэлт, ардын дайснаар тодруулах, буддын шашныг нийгмийн оюун санааны орон зайнаас шахах бодлогын зорилтыг хангав



Түүнчлэн лам нарыг давхраажилтын хувьд устган үгүй хийх олон нийтийн санаа бодол, хандлагыг төлөвшүүлэх нөхцөл орчныг бүрдүүлэх суурь эхлэлийг тавьж, цаашдын хэлмэгдүүлэлт, ардын дайснаар тодруулах, буддын шашныг нийгмийн оюун санааны орон зайнаас шахах бодлогын зорилтыг хангав.

Гэвч монголчуудын амьдралд шашны үзэл номлол, сүм хийдийн нөлөө хэвээр, нийгмийн оюун санааны нэгдэл, хувь хүний сэтгэлгээг эрхшээгч байр сууриа алдаагүй байсан төдийгүй сүсэгтэн олны амьдралын хэв маягт багш шавийн барилдлага, зан үйлд тулгуурлаж ирсэн нүүдлийн мал аж ахуй соёл хүчтэй оршсоор байв.

Ийнхүү монголчуудын ХХ зууны түүх, сэтгэл зүйд гүн “хар мөр”-өө үлдээсэн шашин соёлоо хамгаалах, зүүнтний бодлогыг эсэргүүцсэн үндэсний хөдөлгөөн болох 1932 оны зэвсэгт мөргөлдөөнд нийгмийн бүхий л давхарга оролцож нийт 6000 орчим хүн амь насаа алдсан үймээн болж, түүнийг “лам нарын бослого” хэмээн сурталчлан, улмаар тэднийг хоморголон баривчлах, устгах, нийгмийн дайсан хэмээн ялгаварлах дараагийн алхамд шилжсэн билээ. Үнэхээр ч уг хөдөлгөөнд нам эвлэлийн гишүүнээс жирийн малчин хүртэл оролцож, зэвсэгт мөргөлдөөнөөс гадна дүрвэж зугтах коммунист номлолыг үл ойшоох, гажуудуулах (зүүнтний нугалааны эсрэг) бурхан шашны үзэл, номыг түгээх зэрэг хэлбэрээр оролцож байсныг олон эх сурвалж нотолж байна. (Ганболд.С) (Кузьмин.С, Оюунчимэг.Ж) (Цэрэнбалжир.Д)

Гэтэл уг хөдөлгөөнийг лам нарын эсэргүү бослого хэмээн түүхийн үнэнийг гуйвуулснаар нөлөө бүхий том лам нарыг буудан хороох, сүм хийдийг татан буулган, нураах, шашны төлөө үзэл бодлоо илэрхийлсэн хэнийг ч болов шийтгэх улмаар бурхан шашинд итгэх, дээдлэх итгэл үнэмшлийг сулруулах мэдээлэл, ухуулга, сурталчилгааны таатай боломж бүрдэв. Гэхдээ үйл явц дэс дараатай Коминтерн, БХК(б)Н-ын заавраар алгуур үргэлжилсэн билээ. 1932 оны бослого эхэлснээс

сар гаруйн дараа феодалыг дарах асуудлын нэг шат болох намд харыг элсүүлэх ядуу ба дунд лам нарын эд хөрөнгийн ялгаа ламын асуудалд нугалаа гаргасанд хяналт тавих зэрэг асуудлаар МАХН-ын ТХ-ны 18-р бүгд хурал болж, ангийн тэмцлийг өргөжүүлэх талаар өгсөн Коминтерны заалтыг биелүүлэх нь чухал гэдгийг тэмдэглэж байв. (МУҮТА) Энэхүү заавар зөвлөмжид ардууд ба доод давхаргыг феодал дээд лам нараас салган тусгаарлах, лам нарын дотор хагарал бий болгох хэмээн онцлон заажээ. Улмаар 1932 оны 5 сард өөрсдийн шахалт, нөлөөгөөр бий болсон зүүнтний алдаа завхралыг Монголын хувьсгалчдад тохих зорилготой КИГК ба БХК(б)Н-ын ТХ-ны захиа хэлбэрээр зүүний нугалааг шүүмжилсэн тогтоолоо МАХН-ын ТХ-нд ирүүлжээ. Үүнд:

- Бослого удирдсан феодал дээд лам нарыг хайр найргүй устган, бослогыг маш богино хугацаанд дарах
- Мөн бослогод ардын намаас ба эвлэлээс оргон нийлсэн нэрт болон идэвхтэй гишүүдийг устгах, тайлбарлан ухуулах ажлыг өргөжүүлэх
- МАХН-ын ТХ ба засгийн газар өөрийн алдааг ухамсарлан, олон нийтэд тайлбарлах
- Бослогын удирдагчдын хураасан хөрөнгийг түүнд оролцоогүй ардууд ядуу лам нарт тараах
- Нам эвлэлээс оргогчдыг шийтгэн, намын эгнээнд цэвэрлэгээ явуулах
- Хувьсгалын эсэргүүгийн толгой лам нарыг дарж, лам нарын дунд анги давхарга болгон хуваах курс барин явуулах
- Засгийн газрын нэр хүндийг дээшлүүлж, намын гишүүн биш ардын 50 хувийг түүний ажилд татан оролцуулах

- Соёл ба үйлдвэрлэх хүчийг дээшлүүлэх
- Төв болон орон нутгийн байгууллагын үйл ажиллагааг хянах
- Хамтралжуулах явдлыг ардын сайн дурын хоршооллын анхдагч нэгдлээр солих ажилд яаралтай шилжих
- Хувийн худалдааг дэлгэрүүлэх
- Татвар ба зээлийн бодлогыг дахин хянаж үзэх гэсэн захидалд БХК(б)Н-ын ТХ-ны нарийн бичгийн дарга И.В. Сталин, КИГХ-ны өмнөөс Д.З. Мануильский, О.В. Куусинен нар гарын үсэг зуржээ. (РГАСПИ, 2012)

Ийнхүү зэвсэгт хөдөлгөөний дараа 1932 оны 7 сарын 2-ны өдөр БНМАУ-ын 17-р онц бага хурал хурал-даж, тунхагтаа “шашны хэрэгт оролцож ламыг хар болоход албадаж байгаа, хүн амын сүсэг бишрэлийг доромжилж, шашныг мөрдөн хөөж байгаа хэн бүрийг хатуу шийтгэх болно. Үүний хамт шашныг хувьсгалын эсрэг явдалд ашиглахыг хориглоно. Жас- өөрийн малыг хариуцсан бүрэн эрхтэй эзэн бөгөөд өөрийн хүслээр аж ахуйгаа эрхлэн мал хариулуулах гэрээг хатуу барьж захирамжлах ёстойг зарлажээ. Мөн зэвсгээ хураалгаж эсэргүүцэл үзүүлээгүй бол баривчлахгүй ба эсэргүүцэлд оролцсон гэж шийтгэхгүй” (РГАСПИ, 2012) гэж заажээ. Мөн Ардын хувьсгалын 11 жилийн ойгоор буудан алуулах ялтанд 10 жилээр хорих өршөөл, гадаадад нүүн гараад буцаж (9 сарын 1-ээс өмнө) ирсэн хүмүүс, зэвсгээ хураалгаж номхон байх тухайгаа амласан бослогод оролцогчид (удирдагчид, дээд лам нараас бусад) ялаас чөлөөлөгдөж байв.

Гэвч бослогын үйл явц, шалтгаан, Онц бага хурлын тунхаг, шийдвэрийн талаар төвийн сонин хэвлэлүүдэд бүрэн тайлбар, өгүүлэл, сурталчилгаа үгүй зөвхөн толгойлогчдын хэргийг

шүүн шийтгэсэн тухай мэдээ, хатуу чанга шийтгэхийг шаардсан зарим нэг захидал цахилгаан утас нийтлэгдсэнээс (Ардын үндэсний эрх №36, 1933.5.8) өөр материал үгүй байна.

Энэ нь нэгдүгээрт 1932 оны үндэсний эсэргүүцлийн зэвсэгт хөдөлгөөн эрх баригч нам засгийн бодлогод бодитой нөлөөлж, алдаа завхралаа хүлээн зөвшөөрч байсан төдийгүй Оросын болон Коминтерны зүгээс хатуу сануулга авсан, олон айл өрх дүрвэж, нийгэм, олон нийт айдас түгшүүр, эргэлзээний түрэлтэд автагдсан, зүүнтний болон баруунтны бодлогын сөрөг үр дагавар үргэлжлэн улс орны эдийн засгийг доройтуулсан зэрэг шалтгаантай холбоотой болно. Ийм нийгэм – улс төрийн эгзэгтэй нөхцөл байдалд шашны эсрэг илт дайсагнасан ухуулга сурталчилгаа үр дүнгүй төдийгүй дахин нийгмийг цочроох, үймээнд өдөөх аюулд хүргэх нигууртай болно.

**Т**иймээс доод, ядуу лам нарыг нийгэм, эдийн засгийн амьдралд татан оруулах, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, ажил мэргэжилтэй болгох, төрийн халамж дэмжлэг үзүүлэх зэрэг мэдээллийн “зөөлөн” бодлогыг үндсэн чиглэлээ болгон өөрчлөв. Засгийн газрын төв хэвлэл “Ардын үндэсний эрх” сонинд (1932-1941 он хүртэл) “Ядуу лам нарыг бичиг эрдэмд сургах”, “Ядуу доод ангийн лам нарт эмнэлгийн тусламж үзүүлэх” тухай сайд нарын зөвлөлийн 1934 оны 11 сарын 21 өдрийн 33-р тогтоолыг нийтэлж, 1932 оны зэвсэгт мөргөлдөөний гол буруутнаар том лам, хутагт хувилгаадыг нэрлэж, Монгол улсын тусгаар тогтнолыг үгүй хийх зорилгоор гадаадын хүчин улстай хуйвалдсан (хувьсгалчид өөрсдөө Зөвлөлт Оросын дэмжлэг авч байв) хэмээн дүгнээд тэднийг ардын дайсан гадаадын тагнуул гэж

сурталчлах ажлыг 1936 оны эхнээс дахин сэргээв. Мөн шашин төрийг тусгаарласан тухай 8 зүйлт хуулийг 1934 оны 12 сарын 27-ны өдөр баталж, төвийн хэвлэлд дэлгэрүүлэн тайлбарлаж байв. Тухайлбал, “Ядуу лам нарын онц сайшаалтай зүтгэл хөдөлгөөнийг сонирхоцгооно уу” мэдээнд (АҮЭ №25, 1938.3.9) “...хот хөдөөний тээвэр, зам гүүрийн газарт 300 гаруй лам нар ажиллаж, тэдний 112 нь үргэлжлүүлэн ажиллахаа илэрхийлжээ, лам нарын эвлэлдэн нэгдсэн артелийн ажлыг эрс сайжруулахын тулд ... дүрмийг боловсруулан гаргасан” зэрэг өгүүлэл нийтэлжээ. Түүнчлэн ядуу доод лам нарыг бичиг үсэгт сургах ажлыг Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хэрэв суралцваас цэргийн татвараас 3 жил хэлтрүүлэх, радио, цахилгаан, гэрэл саадгүй тавих элдэв хөнгөлөлт үзүүлэх (АҮЭ №93, 1934.12.4), арваас доошгүй багш нар бүхий түр сургуулийг Улаанбаатар болон бололцоот аймгийн төвд байгуулахыг (АҮЭ №17, 1936.2.10) тогтоолд заасныг мэдээлжээ. Мөн хөдөө орон нутгийн сүм хийд лам нарын асуудлыг багагүй тусгаж байсны жишээ нь Өвөрхангай аймгийн Баянзүрх сумын хүрээний лам Балчиннямбуугийн бичсэн өргөдөл санал хүсэлтийг бүрэн эхээр хэвлэж (Үнэн №111, 1937.10.3), сүм хийдээс ангижирсан лам Дамбийн гэрэл зургийг (Үнэн №192) нийтэлж байсан зэрэг юм. Гэхдээ Монголын зүүн өмнөд хязгаарын Манж-го, Японы зүгээс үзүүлж байсан хилийн будлиан, болзошгүй аюултай холбоотой том нөлөө бүхий лам нарын эсрэг сурталчилгаа сулраагүйг Дотоод хамгаалах газрын даргын хариунаас (Үнэн №6, 1936.1.9) мэдэж болно.

Ер нь 1932 оны шашин, соёлоо хамгаалах, хэт хувьсгалч зүүнтний бодлогын нийгэм эдийн засгийн хор

уршигт туйлдан доройтсон олон нийтийн эсэргүүцлийн зэвсэгт мөргөлдөөн нь Монгол орноо өрнөсөн шашны эсрэг үзэл суртал төдий л амжилт олоогүй төдийгүй нөлөөллийн арга хэлбэрээ олоогүйн үр дүн гэж дүгнэж болно. Үүний тод томруун жишээ бол 1931 онд хэвлэгдэж нийт 3 дугаар гараад зогссон “Бурхангүйчүүдийн эвлэл” хэмээх сэтгүүл бөгөөд зүүнтний бодлогын үеийн Коминтерны шууд шахалт, хэт хувьсгалчдын Зөвлөлт Оросын шашингүйн үзлийн ухуулга сурталчилгааг шууд хуулбарлаж байсныг нийтлэл өгүүлэл нь нотолж байгаа юм. Нөгөө талаар зүүнтний бодлогын үеийн (1928-1932) ард олны сүсэг бишрэлийг гутаан доромжлох, шашны эд зүйлийг хураах, олноор баривчлах, шоронд хорих зэрэг үйл хэргийнхээ үзэл суртлын хэрэгсэл болгож, шашингүйн онол номлолыг түгээх зорилгод сэтгүүлийн нийтлэл чиглэж байжээ.

Сэтгүүлийн эхний дугаарт ч зорилгоо “... МАХН-ын Төв хорооноос удирдан, Бурхангүйчүүдийн Төв Зөвлөлөөс эрхлэн лам нар лугаа тэмцэж, шашныг эсэргүүцэх ажлыг явуулж бүхий үндсэн бодлогыг нийлэх, ... шашны хорт мананд төөрөгдөн яваа олон түмнийг шашны, ардыг мунхруулах хорт харанхуй манангаас ангижруулж, тэдний тархийг Маркс, Лениний суртлаар гэгээрүүлж боловсруулах хэрэгт ... ухуулагч, байлдааны зэвсэг болмуй” (Монголын Бурхангүйчүүдийн эвлэл, 1931) хэмээн тодорхойлжээ. Ийнхүү энэхүү дугаартаа Бурхангүйчүүдийн интернационалаас ирүүлсэн болон түүнийг хүлээж аван Монголын Бурхангүйчүүдийн Эвлэлийн тогтоол, илгээсэн захидал, хотын гишүүдийн хурлаас гаргасан тогтоол, СССР-ийн Бурхангүйчүүдийн Төв зөвлөлд явуулсан утас зэрэг албан

бичгийг эх хувиар нь нийтэлжээ. Тиймээс энэхүү дугаарыг сэтгүүл хэмээн үзэх боломжгүй бөгөөд нэг талаас Бурхангүйчүүдийн эвлэл байгуулсныг нотлох баримт бичиг, нөгөө талаас Коминтерн, Зөвлөлт засгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлснээ харуулах хэлбэр хэмээн дүгнэж болно. Бурхангүйчүүдийн интернационалаас ирсэн захидалд “сүм хийд ба шашин мөргөл болбоос өмхрөн унаж буй хөрөнгөтөн үзлийн эцсийн зэвсэг мөн .... Европын олон жинхэнэ ардыг уриалж лоозон талбих нь сүм хийдээс зайлтугай”, Монголын Бурхангүйчүүдийн эвлэлээс буцаан явуулсан захидалд “Монголын олон түмнийг мэхлэн мунхруулж түмэн бодисын санд үгүй тэнэгийн тэнэг явдлыг үйлдэн дэлгэрүүлж, гадаад дотоодынхон эзэд ноёд түшмэдийн харгис дарлагдал ба баячууд худалдаачны мөлжигдөлд олон зуун он оршуулах явдалд зэвсэг болон туслалцаж байсан тулгуур хүчин нь феодализмын шашин мөн” гэх зэргээр тунхагласан нь тухайн үеийн монголын нийгмийн оюун санаанд үл нийцэх төдийгүй зүүнтнийхний эдийн засаг, шашин соёлын эсрэг хийж байсан уршигт үр дагавартай (богино хугацаанд 7 сая мал харагдсан) холбон үзвээс айдас түгшүүр дагуулж байсан хэрэг.

Сэтгүүлийн дараагийн дугаарт ч “СССР ба Монголын бурхангүйчүүдийн эвлэлийн тухай” гэсэн Зөвлөлт Оросын шашны эсрэг явуулж буй ухуулга сурталчилгааны аргыг танилцуулан, зөвлөмж өгсөн, “Шашин шүтлэгийг Маркс, Ленинээс хэрхэн үзсэн тухай” хэмээх үзэл суртлын орчуулгын өгүүлэл хэвлэгджээ.

Харин гурав дахь дугаарт Жигжиджавын бичсэн “Феодал ёсыг эсэргүүцэх хвьсгал ба Бурхангүйчүүдийн эвлэлийн зорилго” гэсэн сүм хийдийн эдийн

засгийн чадавхыг сулруулж, шашны эсрэг үзэл суртлын ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах хэрэгтэйг зөвлөсөн өгүүлэл нийтлэгджээ. Өгүүлэлд “... лам нарын олонх болох ядуу ба залуу лам нарыг хүрээ хийдээс гаргах явдалд шийдвэрийн түлхэц болох бөгөөд хийд сүмийг задруулах ба дээд ангийн лам нар лугаа тэмцэх явдалд дөхөмтэй” (Монголын Бурхангүйчүүдийн эвлэл, 1931) гэж тодотгожээ. Энэхүү дугаарын бусад мэдээлэл нь өмнөх дугаарын адил Герман, СССР-ийн Бурхангүйчүүдийн байгууллагаас ирсэн захидал, хурлын мэдээлэл болон материализм хэмээх юу болох (Магсар) хамтралын ажил ба бурхангүйчүүдийн зорилго (Лхамсүрэн), шашин лугаа тэмцэхэд латин үсэг сурагтун (Лувсанжамц), Бурхангүйчүүдийн хоёр дугаар түр сургуулийн тухай (Лхамсүрэн) гэсэн өгүүлэл мэдээ нийтлэгджээ.

**С**этгүүлийн нийгэмд үзүүлсэн үр нөлөөг товчхон дүгнэвэл буддын шашны онцлог, мөн чанарт үл нийцэх өрнөд, оросын шашингүй үзлийн онол, аргыг шууд сурталчилсан, Монголын сүсэгтэн нийгмийн үнэлэмж эрхэмлэлд үл ойлгогдох үзэл сурталд түшиглэсэн, бичлэг найруулгын ур чадвар сул, ядмаг орчуулгын өгүүлэл давамгайлсан, албаны, Коминтернд “үзүүлэх тайлан” төдий хэвлэл байжээ.

Харин 1932 оны зэвсэгт мөргөлдөөний дараа хэвлэгдсэн “Лам нарын сэтгүүл” нь (1936-1937, 6 дугаар гарсан) монгол, төвд хоёр бичгээр нийтлэл мэдээллээ түгээж байсан нь лам нарыг бичиг үсэгт сургах нөгөө талаас шашны талаарх нам, засгийн газрын бодлогыг сурталчлах зорилготой холбоотой хэрэг. Зөвхөн 1935-1937 оны хооронд 20000 лам бичиг үсгийн дугуйлан, сургалтад хамрагдаж, бас чиг багагүй



бэрхшээл, зөрчил учирч байсан нь зорилтот бүлэг болох залуу, доод лам нарын хүрээнд үзэл суртлын зохист “унших бичиг” зайлшгүй хэрэгтэй болсноор сэтгүүлийг санаачилсан юм. Нөгөө талаар сүм хийдийн эсрэг зөөлөн бодлого, аядуу нөлөөллийн суртал хийх үүрэг МАН, Засгийн газарт Коминтерн, БХК(б)Н-аас лам нарыг анги, бүлгийн хувьд устгах, том нөлөө бүхий хутагт, хувилгаадыг хоморголон цаазлах тулган шахалтаар ноогдож байсныг ч тэмдэглэх хэрэгтэй. Ийм шахалтыг И.В.Сталин Монголын төрийн тэргүүн П.Гэндэнд үзүүлэхэд “Манай улс хүн ам цөөтэй учир лам нараа хар болгож ажил хийлгэнэ” (Отгонжаргал.С, 2003) “тус улсын гадаад байдал түгшүүртэй байх үед лам нарын асуудлыг хурцатгаж тэдэнтэй тэмцэх гэсэн хүн бол хувьсгалын (улс орны зох.) эсэргүү болно” (БНМАУ-ын түүх (Гутгаар боть), 1969) хэмээн хамгаалж байжээ. Сэтгүүлийн эхний дугаарт ч “Хувьсгалын 15 жилийн ойн баярын тухай” өгүүлэлд “Энэ долоон сарын 11-ний өдөр Монголын хувьсгалын 15 жилийн ой тохиолдож буй. Үүнд бидний Монголын шашны сүм хийдийн лам нараас баяр хүргэх зүйл олон байх амой... Ардын хувьсгалын ачаар Монголын шашин ч харийн эрхшээлээс ангижирч, үндэсний эрх чөлөөг олжээ... лам нарт боловсон эмнэлгийн элчийг тусгайлан гаргаж элдэв өвчнийг эмчлэн эдгэрүүлж буй ба үндэсний үсэг бичигт лам нарыг сургах зэрэгт анхаарлыг талбисаар баймуй... наадмыг цэргийн наадам хэмээн нэрлэгдэж бүхий учир бидний лам нарт огт хамаагүй хэмээн бодож үл болох” зэргээр аядуу нийцэлт байр суурийг онцолжээ.

**С**этгүүлийн энэ дугаарын өөр нэг анхаарал татах өгүүлэл нь Их хүрээний хамба номун хан

Агваанхайдавын “Бурхан шашин их эрдэнээр арван зүгийн ялгуусан бурхан Бодисатва хөвгүүд сэлтэд өргөн илгээсэн захиа бичиг” хэмээх нийтлэл бөгөөд шашин номын ариун суртал, чин сүсэгт Манжийн төр дайсагнан хорлож байсан бол өдгөө ардын засгийн үед мандан бадарч, машид дэлгэрэх ерөөл цаг мөн гэсэн санааг шашны үзэл онол, хэл найруулга утга илэрхийллийн өгүүлэмжээр илтгэжээ. Тухайлбал “шашин надад эзэмшигч лам хувцсыг өмсгөсөн шар дүрстэн Манжийг түшмэдийг амьтны удирдагч хэмээн нэр барьснаас олон ардын болжморын цусыг уугч хон хэрээ олон байх боловч өнөөгийн амьтныг татагч хэмээдэг хэрээ тэд нар ч ертөнцийн найман номын урт хошуугаар эшийн шашны үг утгын хоёр нүдийг цохин ухаж баймуй” гээд төгсгөлд нь сэтгүүлийн зүгээс “Агваанхайдавт шашныг хиргүй барихын эрх тэрийг Монгол ардын засагт дэлгэрч буй цаг үүнд өглөг” хэмээн шашны талаар хэрэгжүүлж буй нам засгийн бодлого нь өмнөх мэргэд, номт багш нарын хүсэл, үйл хэргийн бодит тусгал, үргэлжлэл болохыг нотлохыг зорьжээ. Түүнчлэн жасын мал нь урьд цагт мөнгөний оронд сүсэгтэн олон хонь, үхрийг өргөл болгож байсныг сүрэглэн хадгалуулж, ардаар сайн дураар, сүсгээр идээ цагаа талбиж ирснийг лам нар хятад пүүсний тонолгыг даган дуурайж ядуу ардыг жин дансаар мөлжин идэж, улмаар түшмэдийн яаман газар аваачиж, хэрэг тулган хэдэн хувь илүү авч байгаа нь шашныг хорлож буй тухай, албан татварыг хар шар бүгдээр тэгш өгдөг, Ардын засаг төдийгүй Төвөдийн засаг ч цэргийн татвар төлдөг тухай, европ ёсны эмнэлэгт лам нар олноор эмнүүлэн эдгэрч сэнхэрсэн тоо баримт бүхий мэдээ, лам байсан Чоймбол эмч болсон захидал, ариун цэвэрч ёс, монгол

бичгийн сургуулийн тухай мэдээлэл, ядуу лам нарын гар үйлдвэрлэлийн ашиг тус, зүүн хязгаарын будилаан, уншигчдын сүм хийдэд шавилан суух талаарх асуулт хариулт зэргийг нийтэлжээ.

Сэтгүүлийн 1937 оны дугаарт “шашны захиргааны 9 дүгээр Их хурлын тогтоолын явц” гэсэн мэдээлэлд уг шийдвэрийн хэрэгжилтэд учирч буй алдаа зөрчлийг (гавж, аграмбын шалгалтын дүн, мяндагтны үнэмлэхийг шалгалтгүй олгодог, ядуу лам нарыг ажил хөдөлмөр эрхлүүлэх ажлыг эрчимжүүлэх, европ эмнэлгийн сурталчилгаа хангалтгүй, шашны захиргааны сонгууль, тайланд эрх үгүй гишүүдийг хасах ажил орхигдсон) болоод лам нарын улс төрийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, 18 насанд хүрсэн лам бүр цэргийн бүртгэлд орох, Өлгий, Егүүзэрийн хийдийн лам нарын эсэргүү хэрэг, орон нутгийн сүм хийдийн ёс бус үйлдлийн тухай багц мэдээ зэргийг үргэлжлүүлэн нийтэлжээ. Энэхүү дугаарын гол асуудал, нийтлэл нь “Үнэн, худлын тухай ялгавар хэмээх оршвой” бөгөөд түүнээ хутагт хувилгааны хойд дүрийг тодруулах зан үйл, шалтгаан, үндэслэлд эрс шүүмжлэлтэй хандан логик, учир зүйн тайлбар хийн, асуудал дэвшүүлжээ. Өгүүлэлд “... эдүгээ цагийн хувилгаан нь зүдрэл үгүйгээр бусад нэгэн мунхаг хүний энэ хутагт мөн хэмээн нэрлэсэн төдийгөөр хутагт хувилгаан болдог явдлаас гэрчлэгдэшгүйд хүргэх болой.... Учир иймд бөө онгодууд ч хувилгааныг тодруулахад болохгүй газаргүй бөгөөд мөн түүнийг итгэхгүй хэмээхийн баримтгүй болохоос гадна хаад ноёдоос ч хувилгаан дүрийг танин тодруулсан хэмээх нь бас худал болой” (Лам нарын сэтгүүл, 1937) гэжээ. Мөн энэ дугаарт “Дүр тодруулагч хувилгаан хэмээх хүний тухай” гэсэн

нийтлэлд “Дүр тодруулагч хувилгаан хэмээх хүмүүс ч мөн хүний хойд дүр сонгох цагт эдгээрээс өөрсдийнх нь урьдах, хойдохыг мэдэх зөн мэдрэлгүй” ...томилогдсон дүр хэмээгдэх хүмүүс нь өөр дүр эгэлээс ялгагдах эрдэмгүй атал би яав ч хувилгаан мөн хэмээн түрэмгийлж, санаандаа орсон аливаа үгийг цээргүйгээр чалчин үйлдэж шашин ба амьтанд хорлол хүргэх нь нэн бэрх.... Иймийн тул ийм этгээдийг хутагт хувилгаан хэмээн горьддог нь бухын бөлдгөөс сүү гоожих болов уу хэмээн горьдох лугаа адил...” зэргээр үгүйсгэжээ. Энэхүү өгүүллийн дараагийн нийтлэлийн гарчиг “Хувилгаандаас жирийн ардыг хэрхэн мөлжиж буй тухай өгүүлэх нь” гэсэн байгаа нь өмнөх хоёртойгоо агуулгын болоод ухуулгын зорилгын хувьд агаар нэг буюу тухайлбал “энэ мэт хүн, мал, эд гурвыг хуралдуулан аваад түүний дунд ширээ засаж, дээгүүр шүхрээр бүрхэн, торгонд хөлбөрч, хэрцгий балмад хаан мэт оршиж бүхий атал өөрийн биеийг их хөлгөний хутагт хэмээн чалчиж байх нь бурхны ном лугаа эрс харшлах болой. ... аргат сахиус захиа утлага рилү тэргүүтэн ба өөрийн баас шээсийг хүртэл бусдад өгч, энэ зүйлийг биедээ зүүх буюу хамартаа үнэрлэх, амандаа идсэн төдийхнөөр энэ ба хойд насандаа тустай хэмээн хууран мэхлэх зэрэг ажлуудыг ичгүүргүй үйлддэг болой” зэргээр нэг талаас ард иргэдийн үзэн ядалт, зэвүүцлийг төрүүлэх нөгөө талаас доод ядуу, залуу лам нарт дээд ихэстэйгээ тэрсэлдэх, эргэлзэх нөлөө үзүүлэх зорилгоор нийтлэлийг бичжээ.

Гэхдээ энэхүү шашны мөн чанар, дэг ёс, учир шалтгааныг ухуулан тайлбарлах замаар залуу, ядуу лам нарыг ажил хөдөлмөр, нийгмийн амьдралд татах зорилго бүхий сэтгүүл үргэлжлэн хэвлэгдсэнгүй, төдийгүй

зорилгодоо ч хүрээгүй байна. Энэ нь “Коминтерн болон Сталины удаа дараагийн дарамт шахалтад автагдан 1937-1939 онуудад шашны эсрэг шийдвэртэй довтолж олон мянган лам хуврагийг хоморголон устгаж, соёлын үнэт зүйл болсон сүм хийд хурал номын газруудыг эвдэн бусниулж судар номыг шатаасан” (Норовсүрэн.Л, Сэтгүүл зүй (21 боть), 2019) их хэлмэгдүүлэлт эхэлсэнтэй холбоотой билээ. Хэлмэгдүүлэлт 1922 оноос эхлэн 1937 онд дээд цэгтээ хүрч, 1939 оноос саарсан бөгөөд нийтдээ 45-55 мянга буюу нийт хүн амын 8-13 хувь хөнөөгдсөний 18 мянга орчим нь лам нар байжээ. Түүнчлэн шарын шашны 700 гаруй сүм хийд сүйтгэгдэн, шашин номын зан үйл, эд хэрэглэлийг хориглон, 100 мянга хүрч байсан лам нарын тоо 1940 онд 1147 болтлоо эрс цөөрч нийгмийн давхаргын хувьд устан, оюун санаа, эдийн засагт эзэлж байсан эрх мэдэл байр сууриа алдсан. Ийнхүү гадаад гүрний бодлого, Коминтерны шахалт, хүчирхийлэл хоморголон устгах төрийн үйл, оролцоогоор Монголын шашны гунигт түүхэн үе өнгөрсөн юм.

Гэвч монголчуудын сэтгэл зүрх, итгэл үнэмшил, амьдралын хэв маягт Буддын шашны нөлөө, үнэлэмж хэвээр оршсоор 1990 оны ардчилсан хөдөлгөөн, Зөвлөлтийн улс төр, эдийн засаг, үзэл суртал, цэрэг армийн шууд хараа хяналтаас чөлөөлөгдөн, жинхэнэ утгаар тусгаар улс гэр болох түүхэн цаг үеийг хүрч, шашны дахин сэргэлт, сүсэгтэн олны шүтэх эрх чөлөө, сүм хийдийн хурал номын уламжлал эргэн дэлгэрсэн.

Тиймээс Социализмын үед шашны эсрэг үзэл санааг Монголын тогтмол хэвлэлд БХК(б)Н, Коминтерны шууд шахалт, зөвлөмжөөр, МАН болон Засгийн газраас зохион байгуулалттай,

намч зарчмаар сурталчлан ухуулж байсан ч, лам нарыг нийгмийн давхраа-жилтын хувьд шахан зайлуулж, сүм хийдийг олноор нураасан ч монголчуудын оюун санаа, итгэл бишрэлийн орон зайнаас Буддын шашны онол номлол, зан үйл, үнэлэмжийг үгүй хийж чадаагүй юм.

### Эшлэл

1. БНМАУ-ын түүх II дэвтэр.УБ., 1966, тал 257
2. Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд УБ.,1956. тал 69
3. Норовсүрэн.Л Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм боть I. УБ 2011. Тал 271
4. Дэлэг.Г Монголын хэвлэл, УБ. 1972 он. Тал 32
5. Үнэн №100, 1932, 428 дугаар
6. Бослогын талаар С.Ганболдын “1932 оны бослого дахь цэргийнхний байр суурь” С.Кузьмин, Ж.Оюунчимэг “Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого”, Д.Цэрэнбалжир 1932 оны зэвсэгт бослого, Сталин ба Монгол орон (архивын эмхэтгэл) зэрэг бүтээлээс үзэж болно.
7. МУУТА, МАН-ын баримтын төв х.4, д.4, х.н.185, тал 3
8. РГАСПИ, ф17, оп 162, д12, л. 167-170-эс тат. Монголия в документах коминтера, 2012, х.350-353
9. РГАСПИ, ф.495, оп 152, д 140, л 36-46
10. Монголын “Бурхангүйчүүдийн эвлэл” сэтгүүл. 1931.№1
11. Бурхангүйчүүдийн эвлэл сэтгүүл, 1931. №3
12. Отгонжаргал.С , ХХ зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй, УБ, 2003, тал 73
13. БНМАУ-ын түүх (Гутгаар боть), УБ.1969, тал 356
14. Лам нарын сэтгүүл , 1937, №5, 6
15. Норовсүрэн.Л , Сэтгүүл зүй (21 боть) боть 14, УБ 2019, тал 217

**Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. БНМАУ-ын түүх II дэвтэр.УБ.,1966
2. Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд УБ.,1956
3. Норовсүрэн.Л “Сэтгүүл зүй” (21 боть) боть 14, УБ 2019, тал 217
4. Норовсүрэн.Л Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм боть I. УБ 2011
5. Дэлэг.Г Монголын хэвлэл, УБ. 1972
6. Кузьмин.С, Оюунчимэг.Ж “Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого” УБ., 2014
7. Д.Цэрэнбалжир “1932 оны зэвсэгт бослого, Сталин ба Монгол орон” (архивын эмхэтгэл) УБ., 1990
8. Отгонжаргал.С “XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй”,УБ, 2003,
9. БНМАУ-ын түүх (Гутгаар боть), УБ.1969

**Summary**

In this article, the author discusses the historical research of how propaganda was organized in Mongolia, where Buddhism was widespread at the beginning of socialism. Specifically, from the People's Revolution of 1921 until the Great Repression of 1937, it was shown how the communist government carried out propaganda against clergy and religion in the periodicals of that time.